

МОНГОЛ ДАХЬ ГАДААДЫН ШУУД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

2003-2004 ОНД

1. ОРШИЛ

Гадаадын Шууд Хөрөнгө Оруулалтын тухай үндсэн ойлголт, хөрөнгө оруулалтыг хийх үндсэн зарчмуудын талаар Монголбанкнаас өмнө нь нийтэлж байсан билээ. Түүнчлэн, энэхүү өмнөх Монголбанкны нийтлэлд Монголын хувьд гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ ямар хүчин зүйлсээр тодорхойлогдож болох, бусад шилжилтийн орнуудтай харьцуулахад хэмжээ нь хэр зэрэг түвшинд байсан, нийт эдийн засагт хэрхэн нөлөөлж болох талаар өгүүлж байсан.

Сүүлийн жилүүдэд манай улсад орж ирж буй гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ тогтвортой өссөөр ирлээ. Энэхүү тогтвортой өсч буй хандлага нь ямар хүчин зүйлсээр тодорхойлогдож байгаа, мөн сүүлийн 2 жилд аль салбарт, аль улсаас шууд хөрөнгө оруулалт илүүтэйгээр орж ирж, өмнөх жилүүдээс хөрөнгө оруулалтын нөхцөл байдалд ямар өөрчлөлт гарсан талаар энд тоймлон авч үзэх болно.


2. МОНГОЛ ДАХЬ ГАДААДЫН ШУУД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Монголын эдийн засаг нээлттэй болсон цагаас эхлэн гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ аажмаар боловч тогтвортойгоор нэмэгдсээр ирсэн. Ийнхүү нэмэгдэх болсон нь юуны өмнө Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийг шинэчлэн баталсан болон түүнд оруулсан нэмэлт өөрчлөлтүүд нь хууль эрх зүйн таатай орчинг бий болгож, зохих үр нөлөөгөө өгсөнтэй холбоотой. Нэн ялангуяа сүүлийн гурван жилд гадаадын шууд хөрөнгө оруулалт үлэмж хэмжээгээр нэмэгджээ.

Сүүлийн жилүүдэд дэлхий даяар гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээнд буурах хандлага ажиглагдаж байсан хэдий ч гадаадын хөрөнгө

оруулагчдын зүгээс манай улсыг сонирхох нь улам бүр нэмэгдсээр ирлээ. Нэн ялангуяа олборлох салбар болон худалдаа, үйлчилгээний салбарт Зүүн Өмнөд Ази, Хойд Америкийн хөрөнгө оруулагчид мэдэгдэхүйц хэмжээгээр орж ирж байна.

Гадаадын шууд хөрөнгө оруулалт (сая ам доллараар)
1992-2004 онд



1992-2004 оны хооронд Гадаадын Хөрөнгө Оруулалтын Газарт бүртгэгдснээр дэлхийн 73 улсаас хуримтлагдсан дүнгээр 1.2 тэрбум долларын шууд хөрөнгө оруулалт хийгдэж гадаадын хөрөнгө оруулалттай 3042 компани бүртгэгдээд байна.

3. ГШХО САЛБАРААР

Монгол дахь гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ эдийн засагт хэрхэн нөлөөлснийг тодруулах үүднээс гадаадын шууд хөрөнгө оруулалт болон дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийг голчлох салбар бүрээр нь авч үзье. Энд гадаадын шууд хөрөнгө оруулалтын салбарын ангилал зөвхөн Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлагийн статистикт байдаг гэдгийг өмнөх нийтлэлд дурьдаж байсан бөгөөд ДНБ-ний салбарын ангилал, Гадаадын шууд хөрөнгө оруулалтын салбарын ангилал хоорондоо зөрүүтэй байдагийг анхаарна уу (энэхүү салбарын ангилалыг Хавсралт 1-д харуулав).

Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлагийн статистикийн салбарын ангилалыг Дотоодын нийт бүтээгдэхүүний салбарын ангилалтай дээрхи хүснэгтэд тусгадсанаар харгалзуулан тавьж үзлээ.

Хүснэгт №1 ДНБ, ГШХО-ын өсөлт, салбаруудаар, 2003-2004 онд (хувиар)

ДНБ өсөлт салбараар	2003	2004	ГШХО-ын өсөлт салбараар	2003	2004
ДНБ-ний өсөлт	5.6	10.6	ГШХО-ын өсөлт	11.7	16.3
ХАА, ан агнуур, ойн аж ахуй	5.8	18.9	Малын гаралтай түүхий эд боловсруулалт	37.8	645.1
Боловсруулах үйлдвэр	4.3	1.8	Хөнгөн үйлдвэр	63.2	-28.3
Уул уурхай, олборлох үйлдвэр	-1.3	31.9	Геологи, уул уурхайн эрэл хайгуул, судалгаа, олборлолт	290.5	-1.7
Бөөний болон жижиглэн худалдаа	7.1	2.8	Худалдаа, нийтийн хоол	-92.3	441.9
Барилга	47.6	0.3	Барилга угсралт	-60.1	-24.1
Санхүүгийн гүйлгээ хийх үйлчилгээ	33.6	20.2	Банк санхүүгийн үйл ажиллагаа	-96.4	16707.2

Гэвч энэхүү хүснэгтээр дүгнэлт хийхдээ болгоомжтой хандах нь зүйтэй, учир нь дээрхи салбарын ангиллуудыг зөвхөн ерөнхий чиг хандлагыг нь харах үүднээс ойролцоо чиглэлээр нь харгалзуулан тавьсан болно.

Хүснэгт №1-д тусгагдсан ДНБ-ний өсөлт болон түүний гол салбаруудын өсөлтийн ГШХО-аас хамаарсан мэдрэмжийг тооцсоныг Хүснэгт №2-т харуулав.


Хүснэгт №2 ДНБ-ний ГШХО-аас хамаарсан өсөлтийн мэдрэмж (хувиар)

ДНБ өсөлт салбараар	2003	2004
ДНБ-ний өсөлт	0.48	0.65
ХАА, ан агнуур, ойн аж ахуй	0.13	0.03
Боловсруулах үйлдвэр	0.07	-0.06
Уул уурхай, олборлох үйлдвэр	0.01	-

Бөөний болон жижиглэн худалдаа	-0.1	0.01
Барилга	-0.73	1.4
Санхүүгийн гүйлгээ хийх үйлчилгээ	-0.25	0.0

Хүснэгтээс харахад, ДНБ-ний өсөлтийн Гадаадын шууд хөрөнгө оруулалтаас хамаарсан мэдрэмж нь 2003 онд 0.48 хувь, 2004 онд 0.65 хувь байна. Харин салбараар нь салган авч үзвэл зарим салбарын хувьд 2 жилийн хоорондох өсөлтийн мэдрэмж сөрөг утгатай гарч байгаа нь хөрөнгө оруулалт нь ДНБ-нд хугацааны хувьд хоцрогдолтойгоор нөлөөлж байгаатай холбоотой. Тухайлбал, 2003 онд уул уурхайн салбарт 150.2 сая ам доллартай тэнцэх шууд хөрөнгө оруулалт хийгджээ. Энэ нь хамгийн өндөр өсөлттэй гарсан жил бөгөөд үүний ДНБ-нд үзүүлсэн нөлөө нь 2004 онд илэрч, тухайн жилдээ бууралттай гарсан хөрөнгө оруулалтын хэмжээтэй эсрэг утгатай байжээ. Өөрөөр хэлбэл, хөрөнгө оруулалт, өсөлтийн хооронд сөрөг тэмдэгтэй мэдрэмж гарсан нь эдийн засгийн хувьд алдаатай бөгөөд дээрхи маягаар тайлбарлагдаж байгаа юм. Энд онцлон хэлэхэд, уул уурхайн салбарт оруулсан шууд хөрөнгө оруулалт нь ДНБ-нд богино буюу 1 жилийн хугацаанд эйрэгээр нөлөөлсөн гэж үзсэн нь алт олборлолтын үйл ажиллагааны шинэ технологи, далайцтай өсөлт зэрэгтэй шууд холбоотой. Тухайлбал, Канадын хөрөнгө оруулалттай “Бороо Гоулд” алтны уурхай ашиглалтанд орж тухайн салбарт томоохон хүчин чадал шинээр нэмэгдсэн бөгөөд 2004 онд тус үйлдвэр 7.7 тонн алт боловсруулсан байна.

Гадаадын хөрөнгө оруулалтыг хүлээн авсан салбарын бүтцээр нь харуулбал доорхи байдалтай байна.



Ерөнхийдөө, гадаадын шууд хөрөнгө оруулалт нь нийт эдийн засгийн өсөлтөнд шийдвэрлэх үүргийг гүйцэтгэхгүй байна, учир ДНБ-нийг бүрдүүлэгч бусад салбарууд дахь гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ хангалттай өндөр биш байна.

Геологи уул уурхай, олборлолт

Манай улсын хувьд гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татахуйц олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн харьцангуй давуу тал бүхий гол салбар нь геологи уул уурхай, ашигт малтмал олборлолтын салбар юм. Дээрхи зургаас харахад 2004 оны эцсийн байдлаар Геологи, уул уурхайн эрэл хайгуул, судалгаа, олборлолтын салбарт нийт хуримтлагдсан гадаадын шууд хөрөнгө оруулалтын 62.3 хувь нь ноогдож байна. Өөрөөр хэлбэл, 1991 оноос хойш Монгол дах нийт /cumulative/ гадаадын шууд хөрөнгө оруулалтын дийлэнх нь уул уурхай, олборлох үйлдвэрийн салбарт орж байсан хандлага сүүлийн – жилд хэвээр хадгалагджээ.

2004 оны хувьд Монголд орж ирж буй нийт Гадаадын Шууд Хөрөнгө оруулалтын 46 орчим хувь нь энэхүү салбарт ноогдож байна. Тус салбарт нийт

31 орны 235 гадаадын хөрөнгө оруулалттай компани бүртгүүлсэн бөгөөд нэг компанид ноогдох дундаж хөрөнгө оруулалт нь 2.0 сая америк доллар байна.

Хөрөнгө оруулалтын дийлэнх хэсэг нь Канадын компаниудад (132.0 сая ам. доллар) ноогдож байгаа бөгөөд удаахь байруудад нь БНХАУ-ын (130.0 сая ам. доллар), АНУ-ын (115.0 сая ам доллар) Болгар Улсын (27.0 сая ам долларын) хөрөнгө оруулагчид тус тус орж байна.

Худалдаа, үйлчилгээний салбар

Салбарын энэхүү ангилалд бөөний болон жижиглэнгийн худалдаа, ресторан зоогийн газруудыг хамааруулдаг. Энэхүү салбарт голчлон БНХАУ, БНСУ, Сингапур, Их Британи, Япон, Итали, ОХУ-ын компани, хувь хүмүүс хөрөнгө оруулжээ.

Нэгж компанид ноогдох шууд хөрөнгө оруулалтын хэмжээ нь энэ салбарт хамгийн бага буюу дунджаар 180.0 мянган ам. доллар байна. Монгол улсын импортын тариф 20 хувь /импортын 5, нэмэгдсэн өртгийн 15/ байсаар байгаа нь хэвтээ хөрөнгө оруулалтыг татах хангалттай нөхцөлийг бүрдүүлж чадахгүй хэвээр байна. Үүний оронд гадаадын пүүс, компаниуд бүтээгдэхүүнээ шууд Монголын зах зээл дээр борлуулах нь ашигтай гэж үзэж байгаагаас худалдааны салбарт шууд хөрөнгө оруулалт хангалттай өндөр хэмжээгээр орж ирэхгүй байна. Нөгөө талаас, хэвтээ хөрөнгө оруулалт нь зах зээлийн хэмжээ том байх үед ихэвчлэн орж ирдэг бөгөөд манай улсын хувьд худалдаа үйлчилгээний салбарт орж ирэх гадаадын шууд хөрөнгө оруулалтад нийт зах зээлийн багтаамж сөргөөр нөлөөлсөөр байна.

Хөнгөн аж үйлдвэр

Энд хөнгөн аж үйлдвэрийн сектор нь голчлон хувцас болон сүлжмэл эдлэл үйлдвэрлэх компаниудас бүрддэг. Энэ салбарт шууд хөрөнгө оруулалтынхаа хэмжээгээр Япон улс тэргүүлж (28.0 сая доллар) удаахь байранд нь БНХАУ-ын компаниуд (19.0 сая ам. доллар) орж Хонгонг (8 сая ам доллар), Тайвань (7 сая доллар), БНСУ (7 сая доллар), АНУ (4 сая ам доллар) дараахь байруудад орж байна.

Энэхүү салбарын нэгж компанид ноогдох шууд хөрөнгө оруулалт нь дунджаар 524.0 мянган ам доллар байна. Энэ салбар нь АНУ-аас манай улсад олгогдсон худалдааны нэн тааламжтай нөхцлийн үр нөлөөгөөр эрчимтэй хөгжиж ирсэн бөгөөд гол төлөв экспортод зориулагдсан оёмол, сүлжмэл бэлэн хувцасны үйлдвэрүүдэс бүрддэг. Салбарын гол бүтээгдэхүүнд бүх төрлийн оёмол даавуун хувцас, пальто болон нэхмэл цамц зэрэг бүтээгдэхүүнүүд ордог бөгөөд манай улсын нийт экспортын 1/4 хувийг бүрдүүлж байна. Сүүлийн жилүүдэд БНХАУ дэлхийн Худалдааны Байгууллагад элсэн орсон, Европын Холбоо БНХАУ-ын сүлжмэл эдлэлийн импортод тавих хязгаарлалтаа сулруулах хандлагатай байгаа зэрэгтэй уялдан энэ салбарт орж ирж байсан гададын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ буурах магадлалтай байна.

Малын гаралтай түүхий эдийн боловсруулалт

Ноос, ноолуур, малын арьс, шир боловсруулах үйлдвэрүүдэд БНХАУ, АНУ, Итали, Их Британи болон Японы хөрөнгө оруулагчид зонхилж байна. Тус секторын хувьд дундажаар нэг компанид 342.0 мянган ам долларын шууд хөрөнгө оруулалт ноогддог. Түүнчлэн энэхүү салбар нь ОХУ, Казахстан, Германи зэрэг улсуудын хөрөнгө оруулалтаар боссон мах боловсруулах чиглэлийн үлдвэрүүд мөн хамрагддаг. Энэ салбар нь манай улсын хувьд дэлхийн зах зээл дээр харьцангуй давуу тал олгох бүрэн боломжтой салбар бөгөөд цаашид гадаадын шууд хөрөнгө оруулалтыг дотоодын зах зээлийн багтаамжаас хамааралгүйгээр татах бололцоотой юм.

Мэдээллийн технологи ба харилцаа холбоо

Монголын харилцаа холбооны салбарт тэргүүлэгч гадаадын хөрөнгө оруулагч улс нь Япон улс гэж тооцогддог бөгөөд энэ нь хөдөлгөөнт холбооны тэргүүлэгч оператор Мобиком Компанид оруулсан хэмжээгээр тодорхойлогдож байна. Хоёрдахь том хөрөнгө оруулагч нь Солонгосын компани бөгөөд мөн хөдөлгөөнт холбооны чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг Скайтел компани юм.

Энэхүү салбар нь сүүлийн жилүүдэд маш хурдацтай өсч байгаа хэдий ч мөн л дотоод зах зээлийн багтамжийн улмаас Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг төдийлөн их хэмжээгээр татах бололцоогоор хомс юм.

Банк, санхүүгийн үйлчилгээ

Банкны сектор нь Худалдаа Хөгжлийн Банк, ХААН банкууд хувьчлагдснаар Гадаадын Шууд Хөрөнгө оруулалт хүлээн авсан сектор болсон. Цаашид банкны систем улам бүр тогтворжиж, банкуудын үйл ажиллагаа олон улсын банкны үйлчилгээний түвшинд хүрэхийн хирээр гадаадын хөрөнгө оруулагчдаас Монголын банкуудад хөрөнгө оруулах сонирхол нэмэгдэх болно. Ойрын ирээдүйд, банкуудын дүрмийн сангийн доод хэмжээг нэмэгдүүлсэнтэй холбоотойгоор гадаадын хөрөнгө оруулалттай банкуудын тоо нэмэгдэх магадлал өндөр байна.

4. ГШХО ОРЖ ИРСЭН ЭХ ҮҮСВЭРЭЭР НЬ (УЛСААР)

Сүүлийн жилүүдэд Монгол улсад хөрөнгө оруулсан улс орнуудын тоо өсөн нэмэгдэж байгаагийн дотор шууд хөрөнгө оруулалтын нийт хэмжээгээрээ Зүүн Ази, Хойд Америкийн улсууд зонхилох байр суурийг эзэлж байна. 2004 онд орж ирсэн гадаадын шууд хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг улс улсаар нь Хасралт№2-т харуулав.

Оруулсан шууд хөрөнгө оруулалтынхаа хэмжээгээр БНХАУ нийт дүнгийн 37.9 хувийг эзэлж тэргүүлж байгаа бол удаахь байруудыг Канад улс (13.2 хувь), АНУ (11.4 хувь), БНСУ (8.1 хувь), Япон (6 хувь), ОХУ (3.3 хувь) зэрэг улсууд эзэлж үлдсэн 20.1 хувь нь бусад улсуудад ноогдож байна.

БНХАУ-нь оруулсан шууд хөрөнгө оруулалтынхаа нийт хэмжээ болон хөрөнгө оруулалттай компаний тоо зэрэг 2 үзүүлэлтийн аль алинаар нь тэргүүлэх байр суурьтай байна. БНХАУ-аас хийгдэж буй шууд хөрөнгө оруулалт нь геологи-уул уурхайн (US 153.8 сая ам. доллар), худалдаа үйлчилгээний (92.5 сая ам доллар), барилга угсралт/барилгын материал үйлдвэрлэлийн (30.0 сая ам доллар), хөнгөн үйлдвэрийн (22.9 сая ам. доллар) салбаруудад тус тус өндөр хурдацтайгаар өсч байна.

Канадын хөрөнгө оруулагчид геологи-уул уурхайн хайгуулын чиглэлд идэвхтэй ажиллаж байна, тухайлбал одоогийн байдлаар Монголын нутаг дэвсгэрт бүртгэлтэй, үйл ажиллагаа явуулж буй 23 Канадын хөрөнгө оруулалт бүхий компани байгаагаас 17 нь уул уурхай, хайгуулын дээрхи салбарт ажиллаж байна. Энэхүү чиглэлд үйл ажиллагаагаа хандуулсаар 2002 онд 6.0 сая ам доллар байсан Канадын шууд хөрөнгө оруулалт 2004 оны эцсээр 120.0 сая ам. долларт хүрчээ. Энэхүү өсөлт нь хөрөнгө оруулагч улс орнуудын дунд Канадын эзлэх байр суурийг 15 дугаар байрнаас 2 дугаар байрт ортол өсгөжээ.

АНУ-ын хөрөнгө оруулагчид хөрөнгөө дараахь салбаруудад төвлөрүүлээд байна, үүнд: геологи-уул уурхай буюу газрын тосны хайгуул, олборлолт - 94.3 сая ам. доллар, малын гаралтай түүхий эд боловсруулалт - 6.9 сая ам. доллар, хөнгөн аж үйлдвэр - 4.0 сая ам доллар, барилга угсралт, барилгын материалын үйлдвэрлэл - 2.6 сая ам долларын хөрөнгө оруулалтыг тус тус хийгээд байна.

БНСУ-аас орж ирж буй шууд хөрөнгө оруулалтын хэмжээ тогтмол өссөөр 2004 оны эцсийн байдлаар геологи-уул уурхайн салбарт 12.8 сая ам доллар, хөнгөн аж үйлдвэрийн салбарт 6.7 сая ам доллар, тээврийн салбарт 5.6 сая ам. доллар, харилцаа холбооны салбарт 5.3 сая ам долларын шууд хөрөнгө оруулалтыг хийгээд байна.

Сүүлийн жилүүдэд Японы хөрөнгө оруулагчдын сонирхол мөн л өсөх хандлагатай байна. Одоогоор тэдгээрийн сонирхол нь хөнгөн аж үйлдвэрийн салбарт илүүтэйгээр төвлөрсөн байгаа бөгөөд 2004 оны эцсийн байдлаар энэ салбарт 28.0 сая ам долларын хөрөнгө оруулалт хийгээд байна. Түүнчлэн,

харилцаа холбооны салбарт 8.0 сая ам доллар, худалдаа үйлчилгээнд 3.1 сая ам доллар, малын гаралтай түүхий эд боловсруулах чиглэлд 1.8 сая ам. долларын шууд хөрөнгө оруулалтыг гүцэтгэжээ.

ОХУ-аас орж ирж буй шууд хөрөнгө оруулалт нь мөн л гол төлөв геологи-уул уурхайн салбарт (7.8 сая ам доллар) чиглэгдснээс гадна барилга угсралт болон барилгын материалын үйлдвэрлэл (5.2 сая ам доллар), банк санхүүгийн үйлчилгээ (4.0 сая ам доллар), хүнсний үйлдвэрлэлийн (3.1 сая ам доллар) салбаруудад түлхүү орж ирж байна.

ДҮГНЭЛТ

Ерөнхийдөө Монгол улс дах гадаадын шууд хөрөнгө оруулалт тогтмол өссөөр байгаа хэдий ч уул уурхай, олборлох салбараас бусад салбарт төдийлөн өндөр биш байна. Орж ирсэн хөрөнгө оруулалтын дийлэнх нь байгалын баялагт /уул уурхай, олборлолт/; Монгол улсын АНУ-ын зах зээлд нэвтрэхэд үзүүлж буй хөнгөлөлтийг ашигласан хөнгөн үйлдвэр; ховор түүхий эд болох ноолуурын салбар; үйлчилгээг шууд зах зээл дээр нь нийлүүлэхээс өөр аргагүй нийтийн хоолны салбаруудад чиглэсэн байна. Мөн хэвтээ хөрөнгө оруулалт нь зах зээлийн хэмжээ том байх үед ихэвчлэн орж ирдэг учир энэ төрлийн хөрөнгө оруулалт орж ирэх магадлал бага байна. Босоо хөрөнгө оруулалт худалдааны саад тотгор бага үед орж ирдэг ч тээвэрлэлтийн зардал өндөр, мэргэжлийн ажилчдын хомсдол зэргийн шалтгааны улмаас бага байж болох юм. Эдийн засгийн нийт салбаруудын хэмжээгээр гадаадын шууд хөрөнгө оруулалт нэмэгдэхгүй байгаа нь юуны өмнө газар зүйн байршил, зах зээлийн хэмжээ бага зэргээс шалтгаалж байна.

Гадаадын шууд хөрөнгө оруулалт, ерөнхийдөө, Монгол улсын эдийн засагт эерэгээр нөлөөлсөн гэж дүгнэж болох боловч тухайн салбарт гарсан өсөлт нь зөвхөн гадаадын хөрөнгө оруулалтын нөлөө гэж ойлгох нь учир дутагдалтай юм.

Одоогоор Монгол улсад орж ирж буй гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ нь мөнгөний бодлого хэрэгжүүлэх, инфляцийг бууруулах, ханшийн бодит чангаралтаас сэргийлэх зэрэг асуудал хүндрэл үзүүлэхээр хэмжээнд орж ирээгүй бөгөөд мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхэд хүчтэй нөлөө үзүүлж чадаагүй байна.

ХАВСРАЛТ №1 Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлаг

(мянган ам.доллараар)

№.	САЛБАРУУД	1999	2000	2001	2002	2003	2004	%	Нийт
1	Геологи, уул уурхайн эрэл хайгуул, судалгаа, олборлолт	24,995	16,842	56,937	38,476	150,232	147623.2	38.4	335,213
2	Худалдаа, нийтийн хоол	5,124	5,545	5,154	89,543	6,915	37472.16	14.7	128,466
3	Хөнгөн үйлдвэр	19,175	27,147	4,933	2,885	4,708	21009.2	9.5	83,338
4	Мал аж ахуйн гаралтай түүхий эдийн боловсруулалт	8,297	11,559	6,260	296	408	3375.835	5.8	50,267
5	Инженерийн барилга байгууламж, барилгын материалын үйлдвэрлэл	5,695	8,135	8,149	5,985	2,390	3040.042	5.7	49,502
6	Банк, санхүүгийн үйл ажиллагаа	2,179	701	19,713	4,002	125	2452.553	3.6	31,467
7	Тээвэр	3,739	6,367	582	1,154	2,284	1815.304	2.4	20,957
8	Харилцаа холбоо	3,078	75	160	442	4,091	1184.6	2.4	20,924
9	Соёл урлаг, боловсрол, шинжлэх ухаан, хэвлэл	2,664	5,208	138	3,430	2,391	929.4	2.0	17,540
10	Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл	2,170	1,310	351	2,996	736	444.863	1.6	14,387
11	Аялал жуулчлал	213	304	97	719	826	434.5	1.3	11,424
12	ХАА, газар тариалан, МАА	3,315	253	825	346	86	251.321	1.1	9,510
13	Эрчим хүч	50	1,852	1,113	197	257	204.75	0.6	5,269
14	Мебель, модон эдлэл	932	667	1,094	888	519	90.5	0.6	5,146
15	Эрүүл мэнд, гоо сайхны үйлчилгээ	1,411	505	83	184	480	56.75	0.6	4,825
16	Нийтийн ахуйн үйлчилгээ	338	466	76	31	26	36.8	0.3	2,208
17	Цахилгаан хэрэгслийн үйлдвэрлэл	383	27	5	10	186	25	0.2	1,600
18	Үнэт зүйлс, бэлэг дурсгал		8	34		68	20	0.2	1,364
19	Гэр ахуйн хэрэгслийн үйлдвэрлэл	180	46	60	147	355	17	0.2	1,325
20	Бусад	2,929	6,692	16,997	23,090	19,742	16522.7	9.0	78,790
		86,865	93,707	122,761	174,820	196,821	237,007		873,522
21	Газрын тосны салбар	6,140	10,660	7,480	7,700	6,993	6,993		126,863
	Дүн	93,005	104,367	130,241	182,520	203,814	244,000	100.0	1,000,385

ХАВСРАЛТ № 2 Гадаадын шууд хөрөнгө оруулалт 2004 онд (мянган ам доллараар)

№.	Улсын нэр	Үл хөд. хөрөнгө	Тоног төхөөрөмж	Бэлэн мөнгө	Бусад	Total
1	БНХАУ	68	69,383	56,326	247	126,024
2	Канад	0	0	51,455	0	51,455
3	Их Британийн Виржини арал	0	11	16,517	0	16,528
4	Их Британи	0	6,210	1,245	0	7,455
5	Израил	0	7,155	23	0	7,178
6	БНСУ	209	1,221	4,980	97	6,507
7	Япон	0	29	5,403	0	5,431
8	АНУ	78	1,018	2,137	0	3,233
9	БНХАУ/Гонконг/	0	1,031	2,096	0	3,127
10	Бельги	0	0	2,259	0	2,259
11	ОХУ	0	984	803	471	2,258
12	Багамын арлууд	0	1,000	270	0	1,270
13	Австрали	0	0	728	0	728
14	Антигуа ба Барбуда	0	0	653	0	653
15	Малайз	0	0	500	0	500
16	Кыргыз	0	0	10	469	479
17	ХБНГУ	0	187	231	1	420
18	Чех	0	225	10	0	235
19	Вьетнам	0	0	218	0	218
20	Казахстан	0	204	0	0	204
21	Пакистан	0	0	133	0	133
22	БНХАУ/Тайван/	0	85	42	0	127
23	Энэтхэг	0	0	65	0	65
24	БНАСАУ	0	0	63	0	63
25	Сингапур	0	0	60	0	60
26	Украин	0	0	57	0	57
27	Грек	0	0	44	0	44
28	Итали	0	0	32	0	32
29	Турк	0	0	28	0	28
30	Франц	0	0	25	0	25

31	Сири	0	0	22	0	22
32	Бермуда	0	0	21	0	21
33	Нидерланд	0	0	20	0	20
34	Австри	0	0	19	0	19
35	Польш	0	3	13	0	17
36	Серби Монтенегро	0	0	15	0	15
37	Швейцари	0	0	15	0	15
38	Либер	0	0	14	0	14
39	Шинэ Зеланд	0	0	13	0	13
40	Саудын Араб	0	0	10	0	10
41	Финлянд	0	0	10	0	10
42	Этопи	0	0	10	0	10
43	Кейман арал	0	0	7	0	7
44	Нигер	0	0	5	0	5
45	Эстони	0	0	5	0	5
46	Нэвис арал	0	0	5	0	5
47	Тайланд	0	0	3	0	3
48	Болгар	0	0	2	0	2
	НИЙТ	355	88,746	146,620	1,285	237,007